

"НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ"
УТУГ-ЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 13-ний өдөр

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомж			2023 онд санхүүжих дүн сая.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин	Хувь
1	2	3	4	5	6	6	7	8
ЗОРИЛТ 1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО								
1.1.	1.2. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1” Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн, суралцагчийн хөгжлийг дэмжсэн “Нийслэлийн боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ” /НЗДҮАХ 2.3/							
1.2.1.	1.2.2. Зорилт 1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, барилга ашиглалт, ачааллын коэффициентыг бууруулж, хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжинэ. /НХТЖҮЧ-2.3.1, НЗДҮАХ-2.3.2, ХАХТ-2.3.2.1, 2.3.2.2, НХТ-6.1.23, НХТ-6.1.24, НХТ-6.1.25, НХТ-6.1.26/							
1	1.1.1.1	Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сургуулиудын барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	8,700.0 (нхо, нхо-он дамжих)	Гүйцэтгэлийн хувь	10	20	2023-2024 онд ашиглалтад оруулахаар нийслэлийн төсөвт тусган баталсан 7 сургуулийн барилга байна. Үүнээс газрын асуудалтай 2 ажил, үүнд Чингэлтэй дүүрэг, 8 дугаар хорооны Сургуулийн барилга (640 суудал), Баянзүрх дүүрэг, 12 дугаар хорооны 640 суудалтай сургуулийн барилгын ажил байна. Үлдсэн 5 байршилд сургуулийн барилгын явц дунджаар 30 хувьтай байна. Тайлант хугацааны хэрэгжилт 70 хувь.	70%
2	1.1.1.2	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг үргэлжлүүлнэ.	18,369.7 (нхо-он дамжих)	Гүйцэтгэлийн хувь	14	40	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 1 цэцэрлэгийн гадна инженерийн шугамын ажил, 25 цэцэрлэгийн зориулалттай барилга худалдан авах, 289 цэцэрлэгт тоног төхөөрөмж, 11 орчин үеийн технологи ашигласан гэр цэцэрлэг, 6 иж бүрэн гэр цэцэрлэг, 32 цэцэрлэгийн засварын ажил 100 хувь хэрэгжсэн. Хэрэгжилт 100 хувь.	100 %

3	1.1.1.3	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд цэцэрлэгүүдийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	15,588.5 (нхо, нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	6	20	2023-2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн нийслэлийн төсөвт тусгасан цэцэрлэгийн өргөтгөлийн 6 барилга байна. Үүнээс 3 байршилд барилгын ажлын гүйцэтгэл дунджаар 40 хувьтай байна. Үлдсэн 3 ажлын тухайд Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэгийн зураг төсөв хянагдаж дууссан, барилга угсралтын ажил эхлээгүй байна. Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, 100 дугаар цэцэрлэгийн өргөтгөл барих талбайн газар доорх хэсэг бохирын шугам таарсантай холбоотой байршил солигдон, зураг шинээр хийгдэж байна. Баянгол дүүрэг, 4 дүгээр хороо, 157 дугаар цэцэрлэгийн өргөтгөл нь барилгажин талбайгүйн улмаас гэрээ цуцлагдсан. 2022-2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж нийслэлийн төсөвт тусгасан цэцэрлэгийн барилгын 4 ажлын гүйцэтгэл 75 хувьтай буюу энэ онд санхүүжүүлсэн үнийн дүнд ажлыг бүрэн гүйцэтгэсэн. 2024 онд ашиглалтад оруулахаар тусгасан 6 барилгаас ашиглалтад оруулсан 1, 75 хувийн гүйцэтгэлтэй 1, 25 хувийн гүйцэтгэлтэй 1, газрын асуудал шийдэгдээгүй 2 ажил байна. Үүнд, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо. Тайлант хугацааны хэрэгжилт 90 хувь.	90%
4	1.1.1.4	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажлыг үргэлжлүүлнэ. /9 ш /	3,712.0 (нхо, нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	9	15	2022-2024 онд ашиглалтад оруулахаар нийслэлийн төсөвт тусгагдсан Бага сургууль цэцэрлэгийн 9 цогцолборын барилгын ажлын хувьд 7 барилга дунджаар 35 хувийн гүйцэтгэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, 33 дугаар хороо, Тахилт дахь барилгын ажил 60 хувь,	90%

							үлдсэн 1 барилгын зураг төсөв 10 дугаар сард баталгаажсан тул суурийн цутгалт эхлүүлсэн байна. Тайлант хугацааны хэрэгжилт 90 хувь.	
1.2.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2 “Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.” /НЗДҮАХ 6.1/								
1.2.1. Зорилт 1. Нийслэлийн газрын харилцааны бодлогыг шинэчлэн, цахим системийг нэвтрүүлэн, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. /НХТЖҮЧ-9.19.1, 9.19.2 НЗДҮАХ-6.1.4ХАХТ-6.1.4.1,НХТ-6.1.5/								
5	1.2.1.1	Төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэх газар чөлөөлөлт хийхэд хамтран ажиллана.	26,792.8 (нхо-он дамжих)	Газар чөлөөлөлтийн хувь /м.кв/	70	100	2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээний газар чөлөөлөлттэй холбоотой 58 удаагийн захирамж гарсан. НЗДТГ-т хянагдаж байгаа 6 захирамжийн хүрээнд 51 нэгж талбарын 18.260 м2 талбайг чөлөөлөх ажлын хүрээнд 6,0 тэрбум төгрөгийг нөхөх олговорт олгохоор төлөвлөөд байна. Хэрэгжилт 90 хувь.	90%
1.3.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 3 “Улаанбаатар хотын хөгжлийн хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.” /НЗДҮАХ 6.3/								
1.3.1. Зорилт 1. Улаанбаатар хотын авто замын үндсэн сүлжээг хөгжүүлнэ. / МУХЖТ-5.1.6, НХТЖҮЧ-9.19.1, 9.19.2 НЗДҮАХ-6.3.1, ХАХТ-6.3.1.1, НХТ-6.1.1, НХТ-6.1.29/								
6	1.3.1.1	Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3у/м төмөрбетон гүүрийн барилга үргэлжлүүлнэ.	9,648.9 (нхо-он дамжих, нзс)	Авто зам, км Гүүр, у/м ажлын хувь	40	100	Гүүрийн бетон хийцийн ажил бүрэн дууссан, авто замын барилгын ажлын хувьд асфальтбетон хучилтын ажлыг хийж, 110 кв-т агаарын шугамын тулгуурыг өндөрлөн, зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн. Төлөвлөсөн гүүрийн захын тулгуурын нөлөөлөлд өртсөн 110кВ-ын агаарын шугамын анкер тулгуураар солих ажил, инженерийн шугам сүлжээ шилжүүлэх ажилд нийт 1,200.0 сая төгрөг шийдвэрлэх шаардлагатайг Монгол Улсын Засгийн газарт танилцуулж улмаар 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. Ажлын гүйцэтгэл 85 хувь.	90%

7	1.3.1.2	Наадамчдын авто замаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам, гүүрийн барилга үргэлжлүүлнэ.	12,250.0 (нэс)	Авто зам, км Гүүр, у/м ажлын хувь	40	60	391 у/м гүүрийн 143 дам нуруу цутгасан. Эхний 8 алгасалын 104 дам нуруу угсарч, 12 ригелийн цутгалт авсан. 1-3 дүгээр алгаслалын хавтангын бетон цутгалтыг хийж, 54.8 у/м гүүрийн тэгшилгээний бетоныг цутгах, хэв гажилтын заадас хийх, гүүрийн явган хүний замын хайс бий болгох ажил дууссан. 36.75 у/м гүүрийн дам нуруу угсрах, завсарын бетон цутгах ажлыг гүйцэтгэсэн. 2023 оны нийслэлийн төсөвт нийт 40.1 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд тухайн онд барилгын ажлыг дуусгахтай холбогдуулан үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай талаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанд танилцуулж шийдвэрлэсэн болно. Ажлын гүйцэтгэл 84 хувь.	90%
8	1.3.1.3	Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх авто зам, гүүрийн барилгын ажил үргэлжлүүлнэ.	3,154.7 (нхо-он дамжих)	Авто зам, км ажлын хувь	40	100	Ажил гүйцэтгэх гэрээг 2023.10.01 хүртэл сунгасан. 33 у/м төмөрбетон гүүрийн ажил хийгдэж дууссан. 800 у/м газарт Асфальтбетон хучилтын ажил дууссан ба гэрэлтүүлгийн ажил хийгдэж байна. Авто замын далангийн дүүргэлт, борооны ус зайлуулах ажил хийгдэж байна. Авто замын трассын нөлөөлөлд өртсөн 1 нэгж талбар буюу “Эрэл Групп” ХХК-ийн хашааны газар чөлөөлөлтийг хийгдээгүй улмаас зам барилгын ажил удаашралтай байна. Ажлын гүйцэтгэл 80 хувь.	90%
9	1.3.1.4	Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто замын ажил үргэлжлүүлнэ.	157.6 (нхо-он дамжих)	Авто зам, км ажлын хувь	87	100	Газар чөлөөлөлтийн асуудлаас үүдэн гэрээт ажлын хугацааг 2023.10.31 хүртэл сунгасан. Авто замын эхний хэсэг болох 0.5км авто замын ажил, борооны ус зайлуулах ажил бүрэн хийгдсэн. Үлдсэн 0.14км авто замын ажил газар чөлөөлөлтөөс шалтгаалан хүлээгдэж байна. Ажлын гүйцэтгэл 87 хувь.	90%

10	1.3.1.5	Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто замын ажил үргэлжлүүлнэ.	1,812.9 (нхо-он дамжих)	Авто зам, км ажлын хувь	3	100	Зам барилгын ажил бүрэн хийгдэж дууссан. Байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувь.	100 %
11	1.3.1.6	“Улаанбаатар хотын тогтвортой зам, тээврийн төсөл”-ийг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Төслийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт ажлын 27 хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний гүйцэтгэл 90 хувьтай байна. Үүнд, Өнөр хорооллын гудамж (2.3 км), Үйлдвэрчний эвлэлийн гудамж (5.6 км), Цогц гудамж зам болгох, Нарны замын зүүн өргөтгөх ажил (4 км) ажлуудын тендерийн баримт бичгийг Дэлхийн банканд хянуулахаар хүргүүлсэн. Сэлбэ голын баруун эргээр шинэ (2.5 км) ажил Нийслэлийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу Сэлбэ сэргэлт төсөлтэй уялдуулах үүднээс түр зогсоосон байдалд байсан бөгөөд 2023 оны 4 улиралд хэвийн байдалд шилжүүлсний дагуу ажлыг үргэлжлүүлээд байна. Эдгээр авто замын зураг төсөл болон барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба гэрээний дагуу урьдчилсан зураг төслийг боловсруулсан. Мөн Тээврийн ухаалаг системийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн, Гэрээний дагуу ажил 2024 оны 12 сард дуусна. Баянзүрх дүүргийн 12, 37-р хороодын нутаг дэвсгэр, Нарны замын зүүн захаас Амгалан хотхоны уулзвар хүртэлх 5.6 км замыг иж бүрэн гудамж концепцын хүрээнд шинээр барих ажлын нарийвчилсан зураг төсөл батлагдсан ба	90%

							12 дугаар сард багтаан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. Тайлант хугацааны гүйцэтгэл 90 хувь	
12	1.3.1.7	“Улаанбаатар шинэ тойрог зам” төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх (хотын хойд хэсгээр) авто замын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” барих төслийн хойд хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто зам болон босоо чиглэлийн хоёр авто зам (Нарангийн энгэрээс СХД-ийн Моносын гурван замын уулзвар хүртэлх авто зам болон Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газраас СХД-ийн 1 дүгээр хорооллын баруун талаар Энхтайваны өргөн чөлөө хүртэлх авто зам) нийт 55 км авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023.07.21-ний өдөр “ХЗТ авто зам” ХХК-тай байгуулсан. Уг төслийн 55 км авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын хүрээнд техникийн Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/860 дугаар захирамжаар байгуулсан. Төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын тухайд хөдөлгөөний эрчмийн тооллогыг үндэслэн мэдээллийг боловсруулж, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн. Урьдчилсан зураг төсөл төлөвлөлт хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 40 хувь.	30%
1.3.2. Зорилт 2. Гудамж замын уулзварыг сайжруулж, олон түвшний уулзгаруудыг барина. /НХТЖҮЧ-9.19.1, НЗДҮАХ-6.3.3, ХАХТ-6.3.3.2, НХ2023Т-6.1.7/								
13	1.3.2.1	Уулзваруудыг дахин инженерчлэлээр нэвтрүүлэх чадварыг сайжруулах төсөл арга хэмжээг үргэлжлүүлнэ.	2,158.6 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	50	100	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1547 дугаар захирамжаар Энхтайваны өргөн чөлөөгөөр зорчих нийтийн тээврийн чиглэлийн тусгайлсан эгнээ бий болгох зорилгоор эгнээ тусгаарлах 5500 у/м хайс суурилуулсан.	100 %

							Гүйцэтгэгчээр “Улаанбаатар зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ ажиллаж байна. ЭТӨЧ хойд хэсэгт 7397м, ЭТӨЧ урд хэсэгт 5975м, ЭТӨЧ нийт 13372м, ЧӨЧ урд талдаа 880м, Хойд талдаа 895м, ЧӨЧ нийт 1775м, Наадамчид урд талдаа 4527м, Хойд талдаа 4392м, Наадамчид нийт 8919м хайс тус тус суурилуулахаар судалгаа гаргасан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1547 дугаар захирамжаар Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд “Энхтайваны өргөн чөлөөгөөр зорчих нийтийн тээврийн чиглэлийн тусгайлсан эгнээ” хийж гүйцэтгэхээр 908,600,000 /есөн зуун найман сая зургаан зуун мянга/ төгрөгийг санхүүжилт батлагдсан. Дээрх захирамжийг үндэслэн Нийслэлийн Замын хөгжлийн газраас БЗД-ийн 12-р хороо Офицеруудын ордны тойргоос БГД-ийн 20-р хороо 5 шарын автобусны эцсийн зогсоол хүртэлх Энхтайваны өргөн чөлөө дагуух чиглэлийн тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн тусгайлсан эгнээг бий болгож хайс байршуулах техникийн тодорхойлолтыг батлан Улаанбаатар зам засвар, арчлалтын газартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Ажлын гүйцэтгэл 100 хувь.	
14	1.3.2.2	Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, замын	16,047.8 (нхо-он дамжих, нзс)	Авто зам, км Гүүр, у/м ажлын хувь	3	20	Авто замын ухмалын ажлууд хийгдэж байна. Нийт ухмалын ажлын 45%-ийг гүйцэтгэсэн. Мөн 0.4 кВ-ын агаарын кабель шилжүүлэх ажил хийгдэж байна. Мөн тухайн төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай талаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны	30%

		байгууламжийн ажил үргэлжлүүлнэ.					04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн. 33 нэгж талбарт газар чөлөөлөх шаардлагатай. Ажлын гүйцэтгэл 15 хувь.	
1.3.3. Зорилт 3. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан төмөр замын гарам, авто машины болон явган хүний гүүрэн гарц, нүхэн гарцуудыг шинээр барина. /НХТЖҮЧ-9.19.1, НЗДҮАХ-6.3.4, ХАХТ-6.3.4.1, НХ2023Т-6.1.8/								
15	1.3.3.1	Зайсангийн төмөр бетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлтийг хийнэ.	7,008.0 (нзс)	Гүүр, у/м ажлын хувь	3	50	Баруун талын шинэ гүүрийн ажил бүрэн дуусч, гэрэлтүүлгийг бүрэн хийж, хөдөлгөөнийг нээсэн. 2023 оны нийслэлийн төсөвт нийт 12.2 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд тухайн онд барилгын ажлыг дуусгахтай холбогдуулан үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай. 2023 онд тусгагдаагүй үлдэгдэл санхүүжилт болох 17,508.0 сая төгрөгийн санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанд танилцуулж шийдвэрлэсэн. 2023 онд одоо ашиглаж байгаа хуучин гүүрийг нураалгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зорчуулж 2024 онд буулгаж ажлыг үргэлжлүүлэхээр болсон. Ажлын гүйцэтгэл 55 хувь.	90%
16	1.3.3.2	“Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих” төслийг эхлүүлнэ.	30.94 сая ам.долла р (гз)	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц барих төслийн ТЭЗҮ-г батлуулж, гүйцэтгэгч “Чайна Тисижу Сивил Инженеринг” ХХК-тай 2022 оны 09 дүгээр сарын 30-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Төслийн барилга угсралтын ажлын хүрээнд 4 нүхэн гарцыг 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр шав тавих ёслолыг хийж, Сонгинохайрхан дүүрэг, 5 шарын төмөр замын гармын баруун талын нүхэн гарцын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, үндсэн барилга бүтээцийн ажил 68 хувьтай байна. Геологийн төв лаборатори	70%

							болон Гермес худалдааны төвийн ойролцоох нүхэн гарцын зураг магадлалаар оруулахад бэлэн болсон боловч нэмэлт ажилтай холбоотой түр хойшлогдоод байна. Нарантуул худалдааны төвийн урд уулзварын нүхэн гарцын хувьд загвар зураг батлагдаагүй. Гүйцэтгэгч болон зөвлөх компаниас тухайн уулзварын нүхэн гарцын төлөвлөлтийн талаар нийт 8 хувилбар санал болгосон бөгөөд саналуудыг ач холбогдлоор нь эрэмбэлэх ажил хийгдэж байна. Хэрэгжилт 70 хувь.	
1.3.4. Зорилт 4.Тээврийн хэрэгслийн ил, газар доорх, дэвшилтэт технологи бүхий олон давхар зогсоолуудыг шинээр барьж, зогсоолын менежментийг шинэчлэн сайжруулна. /НХТЖҮЧ-9.19.1, НЗДҮАХ-6.3.6, ХАХТ-6.3.6.1, ХАХТ-6.3.6.2, НХТ-6.1.9, НХТ-6.1.10/								
17	1.3.4.1	Шинээр ил зогсоолуудыг барьж байгуулах ажилд хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Шинээр ил зогсоолуудыг барьж байгуулах ажилд хөрөнгө санхүүжилт батлагдаагүй. Харин авто зогсоолын менежментийг сайжруулах, их багтаамжийн авто зогсоол байгуулах чиглэлээр хотоос орох, гарах товчоодын ойролцоо, дэд төвүүдийн ойролцоо, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийн буудлын ойролцоо, орон сууцны хотхон хорооллын дунд гэсэн 4 төрлөөр их багтаамжийн давхар зогсоол хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс орон сууцны хотхон хорооллын дунд, эрэлт хэрэгцээ, инженерийн шугам сүлжээний төлөв байдал, газар эзэмшилт зэргийг хамруулан авч үзээд боломжит 26 байршлаас 6 байршлыг тодорхойлон гаргасан. Үүнээс хөдөлгөөний нягтаршил ихтэй бүс буюу их тойруу орчим буюу Сүхбаатар дүүргийн 2 болон 7 дугаар хороонд 250-500 авто машины багтаамжтай, цахим системд холбогдсон давхар зогсоолын барилга, угсралтын ажлыг 2024 онд багтаан төр хувийн хэвшлийн түншлэлийн журмаар, харин уг байршлууд дахь зураг төсөл болон гадна дэд	90%

							бүтцийн барилга угсралтын ажил нь (барилга угсралтын ажлаас бусад зардал) 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2023 онд 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 40 хувьтай хэрэгжиж байна. Эхний 2 байршилд хийгдсэн иж бүрэн зураг төсөл, ТЭЗҮ-г үндэслэн 2024 онд орон сууцны хотхон хорооллын дунд 4 байршилд буюу Баянзүрх дүүрэгт 1, Баянгол дүүрэг 3 байршилд төр хувийн хэвшлийн түншлэлийн журмаар их багтаамжийн авто зогсоолын төслийг хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Мөн хотоос гарах товчоодын ойролцоо бүрэн тохижуулсан авто зогсоол барьж байгуулах зорилгоор 3 байршилд буюу Хан-Уул дүүргийн 8-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, Налайх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт Их багтаамжийн зогсоол шинээр барих, менежментийг сайжруулах ажлын зураг төсөл боловсруулах болон гадна дэд бүтэц инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нийслэлийн төсөвт тусган шийдвэрлэхээр төлөвлөж, суурь судалгааны эскиз болон томсгосон төсвийг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 70 хувь.	
18	1.3.4.2	Шинээр газар доорх зогсоолуудыг барьж байгуулах ажилд хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100%	Авто зогсоолын менежментийг сайжруулах, их багтаамжийн авто зогсоол байгуулах чиглэлээр хотоос орох, гарах товчоодын ойролцоо, дэд төвүүдийн ойролцоо, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийн буудлын ойролцоо, орон сууцны хотхон хорооллын дунд гэсэн 4 төрлөөр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс орон сууцны хотхон хорооллын дунд, эрэлт	90%

							хэрэгцээ, инженерийн шугам сүлжээний төлөв байдал, газар эзэмшилт зэргийг хамруулан авч үзээд боломжит 26 байршлаас 6 байршлыг тодорхойлон гаргасан. Энэ онд Сүхбаатар дүүргийн 2 болон 7 дугаар хороонд 250-500 авто машины багтаамжтай, цахим системд холбогдсон давхар зогсоолын барилга, угсралтын ажлыг 2024 онд багтаан төр хувийн хэвшлийн түншлэлийн журмаар, харин уг байршлууд дахь зураг төсөл болон гадна дэд бүтцийн барилга угсралтын ажил нь (барилга угсралтын ажлаас бусад зардал) 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2023 онд 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 40 хувьтай хэрэгжиж байна. Мөн хотоос гарах товчоодын ойролцоо бүрэн тохижуулсан авто зогсоол барьж байгуулах зорилгоор 3 байршилд буюу Хан-Уул дүүргийн 8-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, Налайх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт Их багтаамжийн зогсоол шинээр барих, менежментийг сайжруулах ажлын зураг төсөл боловсруулах болон гадна дэд бүтэц инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нийслэлийн төсөвт тусган шийдвэрлэхээр төлөвлөж, суурь судалгааны эскиз болон томсгосон төсвийг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 70 хувь.	
1.3.5. Зорилт 5. “Дугуйн болон явган хүний замыг хөгжүүлнэ”. /МУХЖТ-5.1.6, НЗДҮАХ-6.3.7, ХАХТ-6.3.7.1, ХАХТ-6.3.7.2, НХТ-6.1.11, НХТ-6.1.12/								
19	1.3.5.1	Граж, хайс хашлага буулгаж, чөлөөлсөн газар дээрх нөхөн	1,970.0 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	90	100	Нийт 188 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь гараж хайс хашлагыг буулгаж, 31 байршилд тохижилт, ногоон	100 %

		сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил зөвлөх үйлчилгээг гүйцэтгэнэ.					байгууламж, хүүхдийн тоглоомын талбай байгуулах зэргээр нөхөн сэргээлт хийгээд байна. Уг ажилд зориулж 2023 оны нийслэлийн төсөвт шилжих 6.6 тэрбум батлагдсан бөгөөд 2023 оны 10 сарын 31-ны байдлаар 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд олгоод байна. Хэрэгжилт 100 хувь.	
20	1.3.5.2	Авто зогсоол, явган болон дугуйн зам, тохижилт ногоон байгууламжийг гүйцэтгэнэ.	5,179.7 (нхо, нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	50	70	Иргэдийн ая тухтай орчинд алхах, дугуйгаар зорчих хэвшлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд явган замыг өргөтгөн ногоон байгууламжийн хамт тохижуулах, нийтийн эзэмшлийн талбайгаас гараж хайс хашлагыг буулган явган болон дугуйн замыг нэмэгдүүлэх зэргээр ажиллаж байна. Нийт 23,960м2 талбайг засварлах, өргөтгөхөөр төлөвлөснөөс 2022 онд 15,330м явган зам, 780м дугуйн зам, 2023 онд 8628м явган зам, 6100м дугуйн замыг шинээр барих болон засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Гүйцэтгэл 100 хувь.	100 %
21	1.3.5.3	Түрээсийн дугуй, скутер үйлчилгээ болон 5000 дугуйн зогсоол хөтөлбөрийн суурь судалгаа, бэлтгэл ажлыг хангахад хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Түрээсийн скүүтер үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Норди Кристал стар компанитай гэрээ байгуулсан. Гэрээнд заасны дагуу 2023 оны 05 дугаар сард 400ш, 8 дугаар сард 600ш скүүтер нийлүүлэхээр төлөвлөсөн. Мөн болон скүүтер үйлчилгээний цахим аппликейшн болон төлбөрийн системийг бий болгохоор Евро Хан компанитай гэрээ байгуулсан боловч ЖЭТ СКҮҮТЕР үйлчилгээ нэвтэрч, зах зээлгүй болсон тул уг төсөл цуцлагдсан.	Үнэл эх бол омж гүй
1.3.6. Зорилт 6. "Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем" төслийг бүрэн хэрэгжүүлнэ. "НХТЖҮЧ-9.20.2, НЗДҮАХ-6.3.11, ХАХТ-6.3.11.3, НХТ-6.1.14, НХТ-6.1.15 "								

22	1.3.6.1	Замын хөдөлгөөний удирдлагын төвийн байрыг шинэчлэнэ.	1,300.0 (нхо, нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	-	40	Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны конторын барилгын удирдлагын нэгдсэн төвийн зориулалтаар баригдаж буй барилгын 9, 10 дугаар давхарт Замын хөдөлгөөний удирдлагын төвийн технологийн удирдлагын байр, талбайг байгуулан гэрээний дагуу урт хугацаанд, тасралтгүй хамтран ашиглаж, ажиллахаар тохирсон. Барилгын ажлыг зураг төсөв боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ба зураг төслийг магадлалаар баталгаажуулах шатанд байна. Хэрэгжилт 10 хувь.	30%
23	1.3.6.2	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлнэ.	8,027.8 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	40	80	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын нэгдсэн систем нэвтрүүлэх төслийн хүрээнд шалган нэвтрүүлэх товчоод, авто замын хяналтын камержуулалт, уулзваруудын гэрлэн дохио тоноглол болон RFID системийн дэд бүтэц бий болсон. Гэрлэн дохиотой уулзвар бүхий 161 байршил 455 RFID уншигчийг байршуулсан. Улаанбаатар хотод нийт тээврийн хэрэгслийн 75 хувь буюу 331800 орчим тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ буюу TAG суурилуулах бөгөөд 2024 онд бүрэн хэрэгжүүлж дусгахаар Зам, тээвэр хөгжлийн яамнаас төлөвлөсөн. Уг төлөвлөгөөний дагуу энэ оны 8 дугаар сараас Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ буюу TAG суурилуулах ажлыг эхлүүлсэн. Тайлант хугацаанд нийт 114 хоногт 33,500 тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна.	70%

24	1.3.6.3	Улаанбаатар хотын замын хөдөлгөөнийг камер, техникээр хянах тогтолцоог бүрдүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	10	30	Уг ажилд зориулж төсөв хөрөнгө батлагдаагүй. “Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх” төслийн 2022 оны хөрөнгө оруулалтын хүрээнд дараах камер, техникээр хянах ажил 2023 онд хийгдсэн. Үүнд, Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээ буюу таван шарын уулзвараас офицерын уулзвар хүртэлх нийт 44 цэгт 45 камер, Баянгол дүүргийн Модны хоёрын уулзвар болон Төмөр замын сургуулийн урд уулзварын 3 цэгт улсын дугаар илрүүлэх, хурд хэмжих, улаан гэрлийн зөрчил, эгнээ байрны зөрчил, давхар эргэлтийн зөрчил илрүүлэх 37 камераар тус тус бүрэн тоногдсон. Хэрэгжилт 100 хувь.	100 %
1.3.7. Зорилт 7. Авто замын ачааллыг бууруулах, зөв менежментийн үйл ажиллагаа, дэд бүтэц, инженерчлэлийн арга хэмжээ авч ажиллана. /НХТЖҮЧ-9.20.2, НЗДҮАХ-6.3.12, ХАХТ-6.3.12.1, НХТ-6.1.16/								
25	1.3.7.1	Их багтаамжийн зогсоол шинээр барих, менежментийг сайжруулна.	5,133.0 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	10	60	Авто зогсоолын менежментийг сайжруулах, их багтаамжийн авто зогсоол байгуулах чиглэлээр хотоос орох, гарах товчоодын ойролцоо, дэд төвүүдийн ойролцоо, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийн буудлын ойролцоо, орон сууцны хотхон хорооллын дунд гэсэн 4 төрлөөр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнээс орон сууцны хотхон хорооллын дунд, эрэлт хэрэгцээ, инженерийн шугам сүлжээний төлөв байдал, газар эзэмшилт зэргийг хамруулан авч үзээд боломжит 26 байршлаас 6 байршлыг тодорхойлон гаргасан. Үүнээс хөдөлгөөний нягтаршил ихтэй бүс буюу их тойруу орчим буюу Сүхбаатар дүүргийн 2 болон 7 дугаар хороонд 250-500 авто машины багтаамжтай, цахим системд холбогдсон давхар зогсоолын	70%

							барилга, угсралтын ажлыг 2024 онд багтаан төр хувийн хэвшлийн түншлэлийн журмаар, харин уг байршлууд дахь зураг төсөл болон гадна дэд бүтцийн барилга угсралтын ажил нь (барилга угсралтын ажлаас бусад зардал) 8.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2023 онд 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Өнөөдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 40 хувьтай хэрэгжиж байна. Эхний 2 байршилд хийгдсэн иж бүрэн зураг төсөл, ТЭЗҮ-г үндэслэн 2024 онд орон сууцны хотхон хорооллын дунд 4 байршилд буюу Баянзүрх дүүрэгт 1, Баянгол дүүрэг 3 байршилд төр хувийн хэвшлийн түншлэлийн журмаар их багтаамжийн авто зогсоолын төслийг хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Мөн хотоос гарах товчоодын ойролцоо бүрэн тохижуулсан авто зогсоол барьж байгуулах зорилгоор 3 байршилд буюу Хан-Уул дүүргийн 8-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 32-р хороо, Налайх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэрт Их багтаамжийн зогсоол шинээр барих, менежментийг сайжруулах ажлын зураг төсөл боловсруулах болон гадна дэд бүтэц инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нийслэлийн төсөвт тусган шийдвэрлэхээр төлөвлөж, суурь судалгааны эскиз болон томсгосон төсвийг хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт 70 хувь.	
1.3.8. Зорилт 8. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттай нэвтрүүлнэ "/НХТЖҮЧ-9.22.3, НЗДҮАХ-6.3.14, ХАХТ-6.3.14.2, НХТ-6.1.18, НХТ-6.1.30"								
26	1.3.8.1	Нийтийн тээврийн үйлчилгээний	21,801.8 (нхо, нхо-	Гүйцэтгэл ийн хувь	30	60	2022-2023 онд нийслэлийн төсөвт тусгагдсаны дагуу сургуулийн хүүхдийн 50 автобус, их	100 %

		автобусны парк шинэчлэлт хийнэ.	он дамжих)				багтаамжийн дизель 224 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Хэрэгжилт 100 хувь.	
27	1.3.8.2	Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/ парк шинэчлэлт хийнэ.	272,220.1 (утхо)	Гүйцэтгэл ийн хувь	-	85	Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтэд зориулж Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргын багцад 45,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг 22.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнг баталсан. Энэ хүрээнд 55 ширхэг их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй SKYWELL маркийн автобус, 10 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжийг худалдан авсан. Худалдан авах ажиллагаанд асуудал үүсэн тул олон улсын тендер шинээр зарлаж, үнэлгээний шатанд байна. Хэрэгжилт 15 хувь.	30%
28	1.3.8.3	Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ барих ажлыг эхлүүлнэ.	45,523.1 (утхо)	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Цахилгаан автобус цэнэглэх төхөөрөмж бүхий автобусны автопарк байгуулахад зориулж 45,523.1 сая төгрөгийг улсын төсөвт тусган баталсан. Үүний дагуу Хан-Уул дүүрэг 10 дугаар хорооны нутаг дэвсгэр Морингийн даваанд 150 автобусны багтаамжтай гадна зогсоол, 220 автобусны багтаамжтай дулаан зогсоол, иж бүрэн сервис үйлчилгээний суваг, ил зогсоол бүхий иж бүрэн автобусны автопаркийн цогцолборын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2023.04.28-ны өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 65 хувьтай байна.	70%
29	1.3.8.4	“Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн тээврийн	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	Төслийн 2 дугаар үе шатны хүрээнд Шилэн кабел суурилуулах ажлыг бүрэн хэрэгжүүлсэн. Автобусны буудал барих ажлын хэрэгжилт 90	90%

		үйлчилгээг сайжруулах” төслийг үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.					хувь, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тоноглол болон камер суурилуулах ажлын гүйцэтгэл 33 хувьтай тус тус хэрэгжиж байна. Төлөвлөгөөний дагуу төслийг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөрт багтаан бүрэн хэрэгжүүлнэ. Хэрэгжилт 85 хувь.	
1.3.9. Зорилт 9. Нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг, олон төрөлт тээврийн төслүүдийг хэрэгжүүлнэ "НХТЖҮЧ-9.20, НЗДҮАХ-6.3.15, ХАХТ-6.3.15.2, НХТ-6.1.19, НХТ-6.1.28/								
30	1.3.9.1	Дүүжин замын тээврийн шинэчилсэн шугамын ТЭЗҮ-ийг боловсруулж, барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	60.7 сая евро (гз)	Гүйцэтгэл ийн хувь	-	100	“Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн 2 дугаар шугамын барилгын ажил гүйцэтгэх (ЕРС) гэрээг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулж, ТЭЗҮ-г 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр эцэслэн батлуулсан. Гүйцэтгэгч талаас нарийвчилсан зураг төсөл боловсруулан ажиллаж байна. Монгол Улс болон БНФУ-ын Засгийн газруудын хооронд 2020 оны 05-р сарын 12-ны өдөр байгуулсан Санхүүгийн хэлэлцээрийг хоёр улс харилцан зөвшилцөж, 2027 оны 12-р сарын 31-ийг хүртэл сунгасан. Уг хэлэлцээрийг үндэслэн гэрээний үнийн дүнгийн урьдчилгаа 20%-ийг гүйцэтгэгч талд шилжүүлэх талаар НЗДТГ-т хүсэлт хүргүүлсэн. Төслийн 1-р шугам буюу Баянхошуу-Ханийн материал-Гэмтлийн эмнэлэг чиглэлийн төлөвлөлтийг судалж, өөрчлөх талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж байна. Мөн гүйцэтгэгч тал уг трассын ЕРС гэрээг цуцлах, шинээр санал болгож буй трассуудын талаар урьдчилсан харьцуулсан судалгаа хийж ажиллаж байна. Гүйцэтгэл 70 хувь.	70%
31	1.3.9.2	Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэг	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	2023 онд төслийн нарийвчилсан зураг төсвийн ажлыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажилласан. “Тулгуурт байгууламж бүхий хөнгөн галт тэрэг”	90%

		нэвтрүүлэх төслийг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.					төслийн 1 дүгээр шугам буюу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооноос Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо хүртэл нийт 15 буудалтайгаар төлөвлөн ТЭЗҮ боловсруулж төслийн суурь судалгаа хийсэн. Кадастрын зургийн цэг тэмдэг тавих, трассын дагуух инженерийн шугам сүлжээ бүхий байр зүйн зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Геодата” ХХК -тай гэрээг байгуулсан. Энэ онд гүйцэтгэгч “Геодата” ХХК -аас эцсийн тайлан хүлээн аваад байна. Мөн Вагон депо, удирдлагын барилга байгууламж баригдах 110.06 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авахтай холбоотой бэлтгэл ажлыг хангасан бөгөөд 3 дугаар сард трассын дагуух эргэлтийн цэг тэмдгийг газарт тэмдэгжүүлэх ажлыг хийж эхлүүлсэн. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэгний 1 дүгээр шугамын вагон депогийн зориулалттай газрын асуудлын хүрээнд “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгслийн вагон депо, дагалдах инженерийн байгууламж, төмөр зам болон авто замын орц гарцын ерөнхий төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах” гүйцэтгэгчээр “Мөнгөн зөрлөг” ХХК шалгарсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр холбогдох хууль, журамд нийцүүлэн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэл 90 хувь.	
32	1.3.9.3	“Тусгай замын автобус буюу BRT” төслийг эхлүүлэх ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	50 сая ам.доллар (гз)	Гүйцэтгэлийн хувь	-	100	2023 онд Улаанбаатар хотын авто замын сүлжээний хөндлөн чиглэлд хэрэгжих “Тусгай замын их багтаамжийн автобус төсөл” (BRT)-ийг эхлүүлэх, суурь дэд бүтцийн хөрөнгө оруулалтад шаардагдах зардлыг шийдвэрлүүлэхээр төлөвлөсөн. Энэ дагуу уг	100 %

							төслийг эхлүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Үүний дүнд шаардагдах зардлыг Азийн хөгжлийн банкны 655,0 сая ам.долларын багц зээлийн эх үүсвэрт хамруулахаар шийдвэрлэсэн. Азийн хөгжлийн банкны 100 мянган ам долларын трасс сонгох техник туслалцаа 2023 оны 6 сард батлагдсан бөгөөд "Тусгай замын их багтаамжийн автобус (BRT)" нэвтрүүлэх төслийн санал болгосон Шугам 1 болон Шугам 2-ын боломжит хувилбарыг судлахаар БНХАУ-аас "Far East BRT" компанийн төлөөлөгчид болон АХБ-ны зөвлөхүүд ажиллаж байна. Гүйцэтгэл 100 хувь.	
1.3.10 Зорилт 10. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зосоолуудыг барьж, зорчигчийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ. "НХТЖҮЧ- 9.22.3, НЗДҮАХ-6.3.16, ХАХТ-6.3.16.1, НХТ-6.1.20, НХТ-6.1.21, НХТ-6.1.22"								
33	1.3.10.1	Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх	2,000.0 (нхо-он дамжих)	Гүйцэтгэлийн хувь	-	30	Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийслэлийн төсвийн авто замын түгжрэлийг бууруулах багц ажлын жагсаалтад 2.0 тэрбум төгрөг баталсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А1506 дугаар захирамжаар Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-д зохион байгуулах эрхийг шилжүүлсэн боловч уг ажил хэрэгжээгүй.	Үнэл эх бол омж гүй
34	1.3.10.2	Нийслэлийн нийтийн тээврийн автобусны 620 дундын буудлыг хотын стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх	-	Гүйцэтгэлийн хувь	-	100	Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолыг дулаан бөгөөд суудал, гэрэлтүүлэг бүхий битүү бүхээгтэй байдлаар бий болгохоор төлөвлөсөн. Уг ажилд зориулж 2023 онд төсөв хөрөнгө батлагдаагүй. Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах" төслийн ажилтай уялдуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай 30 жилийн турш хамтран ажиллах	100 %

		боломжийг бүрдүүлэх ажилд хяналт тавьж дэмжлэг үзүүлнэ.					гэрээ байгуулж, 2018 оноос хойш 230 байршилд автобусны зогсоол байгуулсан “Жи Си Дико Монголиа “ХХК-тай Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас зөвшилцөн 2023 онд 20 байршилд автобусны зогсоолыг стандартад нийцүүлээд байна. Гүйцэтгэл 100 хувь.	
35	1.3.10.3	Улаанбаатар хотын баруун хэсэгт зорчигч тээврийн шинэ терминал байгуулах ажилд хяналт тавьж дэмжлэг үзүүлнэ.	-	Гүйцэтгэл ийн хувь	-	100	2022-2025 онд нийслэл Улаанбаатар хотын баруун болон зүүн талд Зорчигч тээврийн шинэ терминал байгуулахаар төлөвлөсөн. Зорчигч тээврийн баруун терминалын хувьд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Олон улсын худалдаа логистикийн төв ХК, Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК, БНХАУ-ын Чайна Рэйлвэй констракшн корпорейшн ХХК-иуд хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Зорчигч тээврийн зүүн терминал байгуулах ажлын хүрээнд Туушин ХХК гадаад санхүүгийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалтын шийдвэрлэн төмөр замын барилга байгууламжийн дэд бүтцийн ажлыг эхлүүлсэн. Мөн газрын асуудлаа шийдвэрлээд байна. Нийслэлээс 5 км авто зам байгуулах ажилд дэмжлэг хүсээд байна. 2023 онд төслүүдийн хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай бэлтгэл ажлыг хангахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацааны биелэлт 70 хувьтай байна.	70%
1.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 4 “Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийн оновчтой түвшинд төлөвлөж авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах” /НХТ 6.1/								
1.4.1. Зорилт 1. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх хөгжлийн төсөл арга хэмжээний бэлтгэл ажлыг хангана /НХТ 6.1.19/								
36	1.4.1.1	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Улаанбаатар хотод	8,600.0 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	-	50	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А959 дүгээр захирамжаар “Тулгуурт байгууламж бүхий хөнгөн галт тэрэг” төслийг 2023 оны А/77	100 %

		хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг эхлүүлнэ.					дугаар захирамжаар “Шинэ тойрог зам” төслийг “Улаанбаатар Шинэ бүтээн байгуулалт” ХХК-д хариуцуулсан. Ажлын явцын тухайд “Тулгуурт байгууламж бүхий хөнгөн галт тэрэг” төслийн 1 дүгээр шугам буюу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооноос Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо хүртэл нийт 15 буудалтайгаар төлөвлөн ТЭЗҮ боловсруулж төслийн суурь судалгаа хийсэн. Кадастрын зургийн цэг тэмдэг тавих, трассын дагуух инженерийн шугам сүлжээ бүхий байр зүйн зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Геодата” ХХК -тай гэрээг байгуулсан. Энэ онд гүйцэтгэгч “Геодата” ХХК -аас эцсийн тайлан хүлээн аваад байна. Мөн Вагон депо, удирдлагын барилга байгууламж баригдах 110.06 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авахтай холбоотой бэлтгэл ажлыг хангасан бөгөөд 3 дугаар сард трассын дагуух эргэлтийн цэг тэмдгийг газарт тэмдэгжүүлэх ажлыг хийж эхлүүлсэн. “Шинэ тойрог зам” төслийн хувьд хойд хэсэг болох нийт 55 км авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023.07.21-ний өдөр “ХЗТ авто зам” ХХК-тай байгуулсан. Уг төслийн 55 км авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын хүрээнд техникийн Ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/860 дугаар захирамжаар байгуулсан. Төслийн ТЭЗҮ боловсруулах ажлын тухайд хөдөлгөөний эрчмийн тооллогыг үндэслэн мэдээллийг боловсруулж, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн. Урьдчилсан зураг төсөл төлөвлөлт хийгдэж байна. Гүйцэтгэл 100 хувь.	
--	--	--	--	--	--	--	--	--

37	1.4.1.2	Авто замын түгжрэлийг бууруулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих гадаадын зээл тусламжид шаардагдах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэнэ.	1,800.0 (нхо-он дамжих)	Гүйцэтгэл ийн хувь	30	100	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/937 дугаар захирамжаар батлагдсан "Авто замын түгжрэлийг бууруулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих гадаадын зээл тусламжид шаардагдах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээний ажил"-ыг Эм Си Пи Си Жи Ар ХХК нь НХААГ/202212104 дугаартай гэрээний дагуу гүйцэтгэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 476 дугаар тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 62 дугаар тэмдэглэл гарсантай холбогдуулан гэрээт ажлын даалгавар, цар хүрээг тодотгон зохицуулалт хийж 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зөвлөхийн ажлын даалгавраа шинэчлэн баталсан. Гэрээт ажлын хүрээнд "Тулгуурт байгууламж бүхий хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх төсөл", "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн инженерийн хайгуулын судалгаа, байгаль орчны судалгаа зэрэг ажлууд хийгдсэн. Мөн БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто машины нүхэн гарц шинээр барих төсөл"-ийн зураг төсөл, тоо хэмжээ, төсөвт хяналт хийж байна. Бусад шаардагдах тоног төхөөрөмжүүдийг хуваарийн дагуу нийлүүлсэн бөгөөд 2 ш суурин компьютер, тээврийн загварчлалтын программ болох Визум болон Визим нийлүүлэх ажил хүлээгдэж байна. Нүхэн гарц төслийн хүрээнд хийгдэх 3 байршлын зураг төслийн ажил бүрэн дуусаагүй байгаатай холбогдуулан гэрээт ажлын хугацааг сунгахаар ажиллаж байна. Гүйцэтгэл 70 хувь.	70%
ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ								

38	2.1	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	1,759.4 (нт)	Хэрэгжил тийн хувь	-	100	2023 оны 4-р улирлын байдлаар 1,638,780.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,315,424.4 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр хугацаанд нь хүргүүлж төсвийг хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж өр авлагагүй ажиллаж байна.	100 %
39	2.2	Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.	-	Хэрэгжил тийн хувь	-	100	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр авто замын түгжрэл бууруулах арга хэмжээний хүрээнд 601.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээнүүд 2023 он дамжин хэрэгжиж байна. 2023 онд, он дамжин 138.3 тэрбум төгрөг, шинээр 148.8 тэрбум төгрөг, замын сангаас 9.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр авто замын түгжрэл бууруулах арга хэмжээний хүрээнд хэрэгжиж буй 601.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаар зорилт тус бүрийн хүрээнд дэлгэрэнгүй тайлагнасан.	100 %
40	2.3	Шилэн дансны бүртгэлийг хууль тогтоомжид заасан хугацаанд хөтлөнө.	-	Хэрэгжил тийн хувь	-	100	Шилэн дансанд тухай бүр, сар бүр, улирал бүр оруулах мэдээллийг хугацаанд нь байршуулсан. Бүгд Найрамдах Хятад Ард улсын засгийн газрын зээлийн “Төмөр зам доогуур нүхэн гарч барих төсөл”, Францын засгийн газрын зээлийн	100 %

							“Нийслэлийн нийтийн тээвэрт агаарын дүүжин тээвэр нэвтрүүлэх” төслүүдэд эх үүсвэр бүрээр шилэн дансны эрхийг тус тусад нь нээлгэн хөтөлж байна.	
41	2.4	Нийслэлийн өмчийн харилцааны газартай өмч эзэмшлийн гэрээ байгуулах, дүгнүүлэх, эд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн өмчийн харилцааны газартай өмч эзэмшлийн гэрээ байгуулахаар хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй. 2022 оны аудитлагдсан тайланг өмчийн харилцааны газарт хүргүүлсэн. Эд хөрөнгийн тооллогыг жилийн эцэст 1 удаа хийсэн.	100 %
42	2.5	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн орон сууцны корпорацид НТХН-ийн албан хаагчдын орон байрны нөхцөлийн талаарх, орон сууцны хөтөлбөрт хамрагдах сонирхолтой ажилчдын судалгааг 2023.03.17-ны өдөр хүргүүлэв. Бүгд Найрамдах Хятад Ард улсын засгийн газрын зээлийн “Төмөр зам доогуур нүхэн гарц барих төсөл”-ийг 2024 он, Францын Засгийн газрын зээлийн “Нийслэлийн нийтийн тээвэрт агаарын дүүжин тээвэр нэвтрүүлэх” төслийг мөн 2024 онд хариуцан хэрэгжүүлэх тул дунд хугацааны бодлого боловсруулан батлуулах шаардлага үүсээгүй. Иймд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай сургалтыг төлөвлөн, албан хаагчдыг хамруулан ажилласан болно. - БНСУ-д Нийтийн тээврийн шинэчлэл, хамтын ажиллагаа сэдэвт уулзалтад 2 ажилтан, - Сингапурт Зам, тээврийн төлөвлөлт, тооцоолол болон (PTV VISSUM, VISSIM) программын сургалтад 8 ажилтан,	90%

							- ОХУ-ын Москва хотод "Олон улсын нийтийн тээврийн дээд хэмжээний уулзалт-2023" хуралд 2 ажилтан тус тус хамруулж, Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, Архивын Ерөнхий газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад холбогдох ажилтнуудыг хамруулж ажиллав.	
43	2.6	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан Уул дүүрэг 14-р хороо ногоон хэрэм төслийн талбайд байрлах цэцэрлэгт хүрээлэнд хавар болон намар нийт 170 ширхэг мод тарьсан.	100 %
44	2.7	Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн дагалдах хуулийн төсөл буюу Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөд уг асуудлыг зохицуулахаар тусгасан. Уг хуулийн төсөл нь Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр эхний хэлэлцүүлгийг, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, эцэслэн баталсан. 2.2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан НУХАЗТБҮХ-ны IV дүгээр хуралд хуулийн төслийг танилцуулав. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоог 2. НИТХ-ын “Нийслэлийн авто зогсоолын төлбөрийн хэмжээ тогтоох тухай” тогтоолын төсөл, танилцуулга, нөлөөллийн шинжилгээг бэлтгэн НЗДТГ-ын холбогдох албан	100 %

							тушаалтанд танилцуулан ажиллаж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр авто зогсоолын менежментийг сайжруулах ажилтай уялдуулан түр хугацаагаар хойшлуулаад байна.	
45	2.8	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Хуулийн хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого баримтлан ажиллаж байна.	100 %
46	2.9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. Тухайлбал, 2023 онд 3 ажлын байрны сул орон тооны зар мэдээнд хүйсийг дурьдалгүй, байгууллага, нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг ханган ажиллаж байна.	100 %
47	2.10	Хүний нөөцийн мэдээллийн сан бий болгох, хөтлөх, мэдээллийг тогтмол шинэчлэх, хүний нөөцийг мэргэжил, арга зүйгээр хангах, байгууллагын даргын тушаал, шийдвэрийн төслийг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавина.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан erpulaanbaatar.mn системд албан хаагчдын мэдээллийг тухай бүрд нь хөтлөн, шинэчилж, систем ашиглалттай холбоотой мэдээлэл, тодруулгыг тухай бүрт нь өгч ажиллаж байна. Мөн байгууллагын даргын тушаал, шийдвэрийн төслийг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	100 %

48	2.11	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг сайжруулж, хүнд суртал гаргахгүй ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Төслийн нэгж нь “Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих” төслийн гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд уг төслийн МУЗГ-ын оролцооны 1,598,638.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож ажлыг эхлүүлсэн. Мөн төслийн хүрээнд импортоор оруулж ирэх 6.2 тэрбум төгрөгийн үндсэн материал болон дотоодоос худалдан авах 13.5 тэрбум төгрөгийн туслах материалыг гааль, НӨАТ-ийн албан татвараас чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулаад байна. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахдаа холбогдох хууль, журамд нийцүүлэн, үнэн зөв, бодитой тайлагнаж, мэргэжлийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Мөн 2022-2023 оны нийслэлийн төсвийн түгжрэл бууруулах багцаас санхүүжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, хүндрэл саатлыг тухай бүрд нь шийдвэрлүүлэн ажилласан.	100 %
ЗОРИЛТ 3. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ /НИТХ 2022 оны 28 дугаар тогтоол/								
49	3.1	Улаанбаатар хотод тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэг барьж байгуулах, нийтийн тээврийн парк шинэчлэлт, шинэ тойрог зам,	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Түгжрэл бууруулах хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдийн биелэлтийг шуурхай, үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг шаардлагатай маягт загвараар гаргаж холбогдох байгууллагыг мэдээллээр ханган ажиллаж байна.	100 %

		замын байгууламж барих болон нийслэлээс хэрэгжүүлэх бусад “Түгжрэлийг бууруулах төсөл”-үүдийн биелэлтийг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, гүйцэтгэлийн тайлан, мэдээ бэлтгэж зохих журмын дагуу тайлагнана.						
50	3.2	Түгжрэлийг бууруулах чиглэлээр шаардлагатай судалгаа хийх, төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг хангах ажлыг зохион байгуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	2022 онд Нийслэлийн Засаг даргын А900 захирамжийн дагуу авто замын хөдөлгөөний зорчилтын өгөгдөл ба түгжрэлээс үүдэх алдагдсан боломжийн өртөг тооцох аргачлалын талаар мөн нийтийн тээврийн үйлчилгээний менежмен тийг сайжруулах чиглэлээр үндсэн суурь судалгаануудыг хийлгэж авсан. 2023 онд түгжрэл бууруулах чиглэлээр судалгааны ажилд зориулсан төсөв зардал батлагдаагүй. Төслийн нэгжийн дотоод нөөц боломжийг ашиглан замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр дараах нарийвчилсан судалгааг хийж байна. Үүнд, ✓ Уулзваруудын дахин инженерчлэл ✓ Гол гудамж замын дагуух буцах эргэлтийг дахин төлөвлөх ✓ Нэг чигийн хөдөлгөөн зохион байгуулалт ✓ Уулзварын өмнөх буцах эргэлт ✓ Замын хөдөлгөөний зөв менежмент зохион байгуулалт. Мөн шинээр төлөвлөж байгаа төмөр замын нүхэн гарцны замын хөдөлгөөний түгжрэлд	100 %

							үзүүлэх нөлөөллийн тооцоолол, 2022 -2023 онд хэрэгжүүлж буй авто зам, гүүрэн байгууламжуудын нэвтрүүлэх чадвар, замын хөдөлгөөний түгжрэлд нөлөөлөх үр ашгийн тооцооллыг тус тус хийгээд байна.	
51	3.3	Түгжрэлийг бууруулах төслийн талаарх мэдээллийн нэгдсэн сан бий болгоно.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Тайлан хугацаанд Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр үндсэн болон хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 16 байгууллагын мэдээллийг нэгтгэн эхний ээлжийн дата мэдээллийг үүсгэсэн. Үүн дээр үндэслэн Ерөнхий сайдын үүрэг болгосны дагуу 7 хоног бүрийн 3 дахь өдрийн хуралдаанд нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг танилцуулж, холбогдох мэдээллийн санг бүрдүүлж ажилласан. Үүнд, 2023 онд Засгийн газрын хуралдаанд 17 удаа танилцуулга хийж, одоогийн байдлаар Засгийн газрын тогтоол 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 15 тус тус албажин гараад байна.	90%
52	3.4	Түгжрэлийг бууруулах төслийн мэдээллийн санд авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр гаргасан бодлого, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн төлөвлөгөө, Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг НЗДТГ-т тухай бүр ERP нэгдсэн системээр хүргүүлэн ажилласан.	100 %
53	3.5	Түгжрэлийг бууруулах төслийн мэдээллийн системийг төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй уялдуулах, тэдгээртэй мэдээлэл	-	Хэрэгжилтийн хувь	-	100		100 %

		солилцох боломжийг бүрдүүлнэ.						
54	3.6	Эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17.1 дэх хэсэгт заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Хуулийн дагуу өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах, улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100 %
ЗОРИЛТ 4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ								
55	4.1	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ холбогдох бусад ажил хийгдээгүй болно.	100 %
56	4.2	Хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Тус байгууллага нь бодлого, шийдвэр үйл ажиллагааны талаарх мэдээллийг Ulaanbaatar.mn цахим хуудаст мэдээ мэдээллийг нийтлэн иргэд, олон нийтэд хүргэн ажилладаг. Мөн үүний зэрэгцээ олон нийтийн бусад мэдээллийн хэрэгсэлтэй тогтмол хамтран ажиллаж байна. Үүнд, авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээ, 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын талаар 7 сэдвээс бүрдсэн 25 минутын мэдээллийг гэрээлэгч компаниар гүйцэтгүүлэн MYONPT, TV8, TV2, Live TV, TV5, MNC, Парламент, ТМ телевиз болон мэдээллийн 20 сайтаар цацагдсан. Мөн гэрээлэгч компаниар 5 сэдвээр 1 минутын reel	100 %

							бэлтгүүлэн Үндэсний хороонд хүргүүлсэн. Захирал Ч.Батзориг Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн болон шинээр авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар 2023 оны 02, 04, 08, 09 дүгээр саруудад тус бүр хэвлэлийн бага хурал зохион байгуулж, нийт 11 телевизээр мэдээ 33, нэвтрүүлэг 3, зочны ярилцлага 6 удаа, нийт 14 цахим хуудсаар бичвэр болон видео мэдээ 35 удаа, өдөр тутмын сонинд 5 удаагийн мэдээ нийтлүүлэн, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.	
57	4.3	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	RFID систем, нийтийн тээврийн болон хүүхдийн автобусны зорчилтын мэдээлэл, засвартай болон түр хаасан зам, нийслэлийн товчоод, гэрлэн дохионы болон RFID уншигчийн байршил, замын агшны хурдны зөрчил болон бусад зөрчлийн мэдээлэл, зогсоолын байршил болон ашиглалтын мэдээлэл, замын хөдөлгөөний ачааллын мэдээлэл авах боломж бүхий систем /ubmap.ulaanbaatar.mn/-ийг тус тус нэвтрүүлсэн. Энэ онд Зам, тээврийн нэгдсэн систем"-ийн хүрээнд нийслэлд авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлд 442,477 ширхэг цахим гэрчилгээг суурилуулахаар нийслэлээс төлөвлөсөн. Гэвч Зам, тээвэр, хөгжлийн яамнаас цахим гэрчилгээ суурилуулах ажлыг 2024 оны эхний улиралд багтаахаар нэгдсэн төлөвлөгөө баталсантай холбоотой уг хугацаа хойшлоод байна. Энэ оны 8 дугаар сараас Улаанбаатар хотод бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээ буюу TAG суурилуулах ажлыг эхлүүлж, өнөөдрийн байдлаар нийт 114 хоногт 33,500 тээврийн	70%

							хэрэгсэлд цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулаад байна.	
58	4.4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	2023 оны жилийн эцсийн сарын байдлаар нийт 130 өргөдөл, гомдлыг хүлээн авч, өргөдөл, санал, гомдлыг хууль журамд заасан шаардлагын дагуу шийдвэрлээд байна. Эдгээрт нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлд нөлөө үзүүлж буй тул засаж залруулах тухай 95 гомдол, цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа анхаарах тусгах тухай 30 санал, 5 хүсэлт тус тус ERP цахим системээр бүртгэгдэж ирсэн. Өргөдөл гомдлыг хугацаанд нь 100 хувь шийдвэрлэн, иргэнтэй утсаар холбогдон өргөдөл, гомдлын талаар тодруулж асуух, бүрэн дүүрэн хариулт мэдээлэл өгөхөд анхааран ажиллаж байна.	100 %
59	4.5	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөн явуулж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх, албан хэрэг хөтлөлтийг зохих журмын дагуу мөрдөнө.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөн явуулж, ERP системийн E-DOC цэсийн ашиглалтын талаар албан хаагчдад зохих шаардлагыг тавин, зөвлөмж, арга зүйгээр ханган ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар байгууллагад нийт 543 албан бичиг хүлээн авсан. Хариутай албан бичиг 101 бөгөөд шийдвэрлэлт 93,02 хувьтай байна. Мөн хамтрагч байгууллагууд руу 394 албан бичиг явуулсан.	100 %

60	4.6	Төсөл, хэмжээний олон сурталчлах, таниулна.	арга талаар нийтэд	-	Хэрэгжил тийн хувь	-	100	Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээ, 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын талаар 7 сэдвээс бүрдсэн 25 минутын мэдээллийг гэрээлэгч компаниар гүйцэтгүүлэн MYONPT, TV8, TV2, Live TV, TV5, MNC, Парламент, ТМ телевиз болон мэдээллийн 20 сайтаар цацагдсан. Мөн гэрээлэгч компаниар 5 сэдвээр 1 минутын reel бэлтгүүлэн Үндэсний хороонд хүргүүлсэн. Захирал Ч.Батзориг авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүн болон шинээр авч хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар 2023 оны 02, 04, 08, 09 дүгээр саруудад тус бүр хэвлэлийн бага хурал зохион байгуулж, нийт 11 телевизээр мэдээ 33, нэвтрүүлэг 3, зочны ярилцлага 6 удаа, нийт 14 цахим хуудсаар бичвэр болон видео мэдээ 35 удаа, өдөр тутмын сонинд 5 удаагийн мэдээ нийтлүүлэн, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан. Нэгтгэвэл, 2023 онд хэвлэл мэдээллийн 28 хэрэгслээр 90 гаруй удаагийн мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж ажиллав.	100 %
----	-----	---	--------------------------	---	-----------------------	---	-----	---	-------

ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

БОЛОВСРУУЛСАН:

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Ч.БАТЗОРИГ

С.ХАЖИДСҮРЭН

Signature

Д.ЖАРГАЛМАА

"НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ" УТУГ-ЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Дугаар	Зорилтын биелэлтийг хувиар (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын журам аргачлалаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго		
1	100 хувь	10
2	90 хувь	13
3	70 хувь	8
4	30 хувь	4
5	0 хувь	2 Үнэлэх боломжгүй
ЗОРИЛТ 2. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ		
1	100 хувь	10
2	90 хувь	1
3	70 хувь	-
4	30 хувь	-
5	0 хувь	-
ЗОРИЛТ 3. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРЭГ		
1	100 хувь	5
2	90 хувь	1
3	70 хувь	
4	30 хувь	
5	0 хувь	
ЗОРИЛТ 4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ		
1	100 хувь	5
2	90 хувь	
3	70 хувь	1
4	30 хувь	
5	0 хувь	
Нийт арга хэмжээний тоо	60 арга хэмжээ	
1	100 хувь	30
2	90 хувь	15
3	70 хувь	9
4	30 хувь	4
5	0 хувь	2 Үнэлэх боломжгүй
Биелэлтийн дундаж хувь	“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 87.9 хувь	

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжидгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.7 дахь хэсэгт заасныг үндэслэл болгон 6.2 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу хэрэгжилтийн үнэлгээг тооцов.

Дараах 2 арга хэмжээг “Үнэлэх боломжгүй” гэж тооцов. Үүнд:

1. Төлөвлөгөөний 21 дүгээрт “Түрээсийн дугуй, скутер үйлчилгээ болон 5000 дугуйн зогсоол хөтөлбөрийн суурь судалгаа, бэлтгэл ажлыг хангахад хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ” гэж заасны дагуу нийслэлийн төсөвт хөрөнгө тусгаадаагүй, зах зээл байхгүй гэж үзсэн учир уг арга хэмжээ хэрэгжээгүй.

2. Төлөвлөгөөний 33 дугаарт “Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих, шинэчлэх” гэж заасны дагуу нийслэлийн төсөвт 2.0 тэрбум төгрөг баталж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А1506 дугаар захирамжаар Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-д зохион байгуулах эрхийг шилжүүлсэн боловч уг ажил хэрэгжээгүй.